



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



Japan
Fund for
Poverty
Reduction

ХАЛГАЙГААР ТЭЖЭЭЛ БЭЛТГЭХ АРГАЧЛАЛ

Халгай

Олслог халгай. (*Urtica cannabina*). Манай орны хаана ч, ялангуяа ойт хээрийн бүс, хээрийн бүсийн умарт хэсгийн чийгтэй хөндий, жалга гуу, өвөлжөө хаваржаа, тариа ногооны талбайн эргэн тойронд болон суурин газрын орчмын сул хөрст газарт ихэвчлэн ургана. Халгай нь 130 см хүртэл өндөр ургах боловч харин цэцэглэлтийн үедээ 40-60 см өндөр, иш нь бүдүүрч хатаагүй, шим тэжээл илүүтэй, витаминлаг байх тул энэ хугацаанд малын тэжээлд хадаж бэлтгэхэд тохиромжтой.

Ач холбогдол

Халгай протеины (уураг) агууламжаар тэжээлийн нэг, олон наст үет ургамлуудаас дутуугүй бөгөөд "С", нэн ялангуяа ургамал болгонд их биш каротин буюу "А" витамин агууламжаар 2-3 дахин илүү, сувилалын чанар гойд сайн олон наст өвслөг ургамал юм.

Халгайн ханд бэлтгэх арга

Халгайг 6-7 сард ургаж буй үед түүж хэрчээд нэг кг тутамд 10-20 г давс буюу 100-150 гр хивэг хийж янз бүрийн хэлбэртэй хэвтэй шахаж сүүдэрт хатаана.

Мөн хэрчиж жижиглээд сүүдэр газар дэлгэж хатаан халгайгаар ханд бэлтгэхдээ 2 кг халгай тутамд 10 л ус хийж 30 минут орчим буцалгаад таглан 1-2 цаг хучиж дулаан байлгасны дараа маарлаар шүүн ханданд хоолны давс нэмж уусгаад хурга, ишгэнд 30-50 мл унага, тугалд 50-100 мл өдөрт 3-4 удаа өгнө.



Тарих арга техник

Манай байгаль-уур амьсгалын аль ч бүс, бүслүүр нутагт халгайг тариалах боломжтой. Хүчирхэг ургасан халгайн нэг бут ургах чадвар сайтай олон зуун үр өгдөг. Бага газраас ахиухан ургац авахын тулд үрээр тариалж халгайн төгөл бий болгох хэрэгтэй. Зуншлага эрт эхэлсэн жил халгайн үр IX сарын эхний 10 хоногт бүрэн гүйцэт боловсордог. Халгайн ишний салаануудын үр цуварч боловсордог. Түрүүчийн боловсорсон үрийг түүвэрлэн

гараар хураах хэрэгтэй. Халгайн үрийг нэгэн жигд бор шаргал өнгөтэй болох үед түүнэ. Боловсорч гүйцсэн үрийг зузаан бээлийтэй гараар шувтарч авна. Эсвэл үр бүхий салааг хайчлан авч бүрэн гүйцэт хатсаны дараа цайруулж болно. Нойтон үр амархан халж, хөгцөрч ургах чадваргүй болдог. Иймээс хурааж авсан үрийг тун богино хугацаанд бүрэн гүйцэт хатаах хэрэгтэй. Хатаасан үрийг чийг авахааргүй хуурай, сэрүүн, харанхуй газар хадгална.



Хураалт

Нялх халгайг (8-10 см) хүнс болон эмчилгээ сувиллын зориулалтаар ашигладаг. Үүний зэрэгцээ 30-50 см өндөр болох үед хурааж сувиллын чанар сайтай төрөл бүрийн тэжээл (витамнт өвсний гурил, өвсөн дарш, сорс, нухаш) бэлтгэж болно.

Мал тэжээх тооцоо

Ногоон үед нь үхэр тэмээ хонь ямаа халгайг дунд зэрэг иднэ шувууны тэжээлд нэн тохиромжтой. Малчид халгайг хангайг хандалж турж эцсэн малын тэнхрүүлэх тэжээлд ашиглах нь илүү үр дүнтэй.

Боловсруулсан: МAAЭШХ-ын эрдэм
шинжилгээний ажилтан Д.Сангажав